



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 03 сарын 26 өдөр

Дугаар А/159

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар батлагдсан Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.1.6 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 28 дугаар тогтоолоор батлагдсан "Аймгийн шагналын журам"-ын 1.2.9, 3.3.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Ардын хувьсгалын 100 жил, Ховд аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг тохиолдуулан Төрийн байгууллагын соёл, дэг журмыг сахиж, ард иргэдэд төрийн үйлчилгээг түргэн, шуурхай хүргэх нөхцөл бүрдүүлэн, байгууллагын хөгжилд хувь нэмэр оруулан ажиллаж буй Жаргалант сумын Засаг даргын Тамгын газрын сум хөгжүүлэх сангийн мэргэжилтэн Н.Балт, жижүүр О.Мөнхбилэг, жолооч Ч.Булганбат нарыг аймгийн Засаг даргын Хүндэт өргөмжлөлөөр шагнахад 90000 төгрөгийг хавсралтаар баталж, зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 90000 төгрөг/ ерэн мянган/-ийг Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д зөвшөөрсүгэй.

3.Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/159 Ch
02 1943

Аймгийн Засаг даргын 2021 оны
03 дугаар сарын 26-ны өдрийн
А/159 дүгээр захирамжийн хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН “ӨРГӨМЖЛӨЛ”-ӨӨР
ШАГНАГДАХ ХҮМҮҮСИЙН НЭРС

№	Овог нэр	Байгууллагын нэр	Албан тушаал	Мөнгөн дүн
1.	Ч.Булганбат	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	ЗДТГ-ын жолооч	30000
2.	О.Мөнхбилэг	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	ЗДТГ-ын жолооч	30000
3.	Н.Балт	Жаргалант сумын Засаг даргын Тамгын газар	ЗДТГ-ын сум хөгжүүлэх сангийн мэргэжилтэн	30000
ДҮН				90000

-оОо-